

“БАЯНХОНГОР ЭРЧИМ ХҮЧ” ЦТ ХХК

Огноо: 2019 оны 02 дугаар сарын 28-ний өдөр

БАРАА НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН АВАХ БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: “Баянхонгор Эрчим хүч” ЦТ ХХК-ийн 2019 онд
шаардлагатай түлш шатахуун нийлүүлэх

**Харьцуулалт/
гэрээний дугаар:** БХЭХЦТХХК/201906

Баянхонгор аймаг 2019 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

[Баянхонгор Эрчим хүч” ЦТ ХХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **2019 онд шаардлагатай түлш, шатахуун]**–ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 (Тавин мянган) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг **[2019 оны 03 дугаар сарын 08-ны өдрийн 11 цаг]**-аас өмнө өөрийн аж ахуй нэгжийн цахим гарын үсэг, хувийн нууцлалын кодоор www.tender.gov.mn сайтад нэвтэрч цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **[2019 оны 03 дугаар сарын 08-ны өдрийн [11 цаг 10 минут]**-д “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн №3 тоот өрөөнд нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх.Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Баянхонгор аймгийн “Баянхонгор Эрчим хүч” ЦТ ХХК-ийн
2 давхарт №3 тоот өрөө, Утас:70442864**

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
1.1.Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
2.1.Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл
3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
4. Тогтмол үнэ
4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
7.1.Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-**
д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.

| ТОӨЗ-ны | холбогдох Шалгуур үзүүлэлт заалт |
|----------|---|
| ТОӨЗ 1.1 | <p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Энэхүү тендерийн бичиг баримтад тусгагдсан жишиг маягтын дагуу багц тус бүрээр гаргаж баталгаажуулсан үнийн санал ирүүлэх 2. Нийлүүлэлтийн баталгаажуулсан график ирүүлэх 3. Улсын бүртгэлийн гэрчилгээг нотариатаар баталгаажуулсан хуулбар 4. Урт хугацааны болон хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаар Монгол банкны тодорхойлолт эсхүл харилцагч бүх банкнаас ирүүлэх 5. Харилцагч Татварын байгууллагаас өр төлбөргүй тухай лавлагаа тодорхойлолтыг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сан e-balance- аас тендерт оролцогчдын татвар төлөлт, санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг шалгана. /Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байх/ 6. Шүүхийн байгууллагаас сүүлийн 3 жилтэй холбогдох тодорхойлолт ирүүлэх. 7. Шүүхээр шийдвэрлэгдсэн өртэй эсэх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт ирүүлэх. /Хугацаа тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байх/ 8. Харилцагч Нийгмийн даатгалын байгууллагаас өр төлбөргүй тухай лавлагаа тодорхойлолт ирүүлэх. /Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байх/ 9. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: /2018,2017/ оны санхүүгийн тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулсан хуулбарыг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сан e- balance-аас тендерт оролцогчдын татвар төлөлт, санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг шалгана. 10. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил /2017, 2018/ гэрээг хавсарган ирүүлэх. 11. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил /2017, 2018/ 12. Сүүлийн 2 жил /2017, 2018/ оны борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн дундаж нь санал болгож үнийн дүнгийн 70 хувиас багагүй байх байна. 13. Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: Сүүлийн 2 жил Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онуудын аль нэг жилд санал |

| | |
|--|---|
| | <p>болгож буй үнийн дүнгийн 80 хувиас багагүй хэмжээний ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байна. Гэрээг хавсарган ирүүлнэ.</p> <p>14. Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: Гэрээг хэрэгжүүлэх ажлын байр, шаардлагатай тоног төхөөрөмж, өөрийн болон түрээсээр эзэмшигч тухайгаа нотлох баримтаар ирүүлэх.</p> <p>1. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: <i>санал болгож буй үнийн дүнгийн 50%-иас багагүй эргэлтийн хөрөнгийн эх үүсвэртэй байх ба энэ хэмжээний зээлийн эх үүсвэрийг шууд авах боломжтойг нотлох баримт ирүүлэх.</i> /Банкны судлан үзэж зээл олгох боломжтой гэх судлагдаагүй мэдэгдлийг үнэлгээнд харгалзахгүй, судлагдсан зээлийн тодорхойлолт байх/</p> <p>15. Тухайн тендерт оролцогч, түүний нийлүүлэх бараа нь захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолт болон стандартад нийцэж буйг нотлох мөн барааг бүтэн жилийн хугацаанд тасралтгүй гэрээний дагуу нийлүүлэх боломжтойг нотлох баримт холбогдох мэдээллийн хамт тусгайлан бэлтгэж ирүүлэх.</p> <p>16. Гэрээг хэрэгжүүлэх, удирдах болон голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл: Удирдах болон голлох ажилтнуудын сургууль төгссөн диплом, мэргэжлийн үнэмлэхний хуулбар, нийгмийн даатгалын дэвтэрийн хуулбар арын тушаалын хэсгийг оруулсан байх мөн Байгууллагын 2019 оны 01 дүгээр сарын нийгмийн даатгалын НД-7,8 маягтыг хавсарган ирүүлнэ</p> <p>17. Татвар, хураамж, төлбөрөө төлсөн эсэхийг тендер нээсэн өдрөөр тооцно. Татвар, нийгмийн даатгал, банк, бусад байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөртэй, ял шийтгэлтэй болох нь холбогдох байгууллагуудаас ирүүлсэн тодорхойлолтоор нотлогдсон тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>18. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1- д заасан нөхцөл байхгүйг бичгээр ирүүлэх. /Тендерт оролцогч нь үнэлгээний хорооны гишүүдэд нөлөөлөх, нөлөөлөхийг оролдсон нь баримтаар нотлогдвол тендерээс татгалзана.</p> <p>19. ТШӨХ-д заасан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>20. Тендерт оролцогч аж ахуй нэгж нь тендерийн баримт бичгийн дагуу материалаа эмх цэгцтэй, харагдахуйц тод бэлтгэж ирүүлнэ. /Ирүүлсэн материалын харагдах байдал</p> |
|--|---|

| | |
|-----------------|---|
| | <p>хангалтгүй тохиолдолд тухайн материалыг хангалтгүйд тооцож үнэлгээнд харгалзахгүй/ 21.Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: Шатахуун нийлүүлэх зөвшөөрөлтэй байх, Чанарын сертификаттай байх 22. Нийт төсөвт өртөг : 50 000 000 төгрөг</p> |
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: Баянхонгор аймгийн Баянхонгор-Эрчим хүч” ЦТ ХХК Давхар болон өрөөний дугаар: 2 давхарт 03тоот өрөө Ерөнхий инженер Огноо: 2019 оны 03 дугаар сарын 8-ны өдөр Цаг: 11 цаг 00 минут</p> |
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК Давхар болон өрөөний дугаар: 2 давхарт 03тоот өрөө Огноо: 2019 оны 03 дугаар сарын 08-ны өдөр Цаг: 11 цаг 10 минутад</p> |
| ТӨӨЗ 6.2 | <p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Дараах багцаас бүрдэнэ.</p> |
| | |

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

“Баянхонгор –Эрчим хүч” ЦТ ХХК-ийн нийлүүлэх шатах, тослох материалын техникийн тодорхойлолтын хураангуй:

Нийлүүлэгдэх бараа нь дор дурдсан тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Тоо / Хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Тодорхойлолт |
|---|--|-------------|--------------|-------------|----------|--|
| 1 | А-92 | Литр | 3500 | | 4200.0 | - Чанарын сертификатай сертификатай байх - Олон улсын стандартад нийцсэн - Шатах тослох материалыг худалдах үнийн хувьд тогтвортой, хамгийн бага түвшинд барих |
| 2 | А-80 | Литр | 2500 | | | |
| 4 | Дизель түлш | Литр | 15000 | | | |
| 5 | Тосол, мотр кропны тос, Гидрийн шингэн | Литр | | | | |
| | Нийт | | | | | |

Жич: Санал болгож буй үнийн дүнд нөат болон бусад бүх зардал багтсан байна.

Стандарт: Тухайн барааны гарал үүсэл нь зохих стандартад нийцсэн байна. Үүнд стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.

1. Бараа хүргэх газар: “Баянхонгор Эрчим хүч” ЦТ ХХК
2. Бараа нийлүүлэлтийн хуваарь: Гэрээ байгуулсан өдрөөс хойш 300 хоног Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл | Тодорхойлолт | Барааны гарал үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|-----------|--------------|---------------------------|------------|----------|----------|-------------------------------|----------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |

| | | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|--|
| | | | | | | | |
| | | | | | | | |

Тендерийн нийт үнэ

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч, холбоо барих хаяг/утас/фа кс | Гэрээний үнийн дүн | Гэрээний эхлэх хугацаа | Гэрээний дуусах хугацаа |
|--------------|---|-----------------------|---------------------------|-------------------------------|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |
| бусад. | | | | |

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Шалгах болон турших** 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. **Барааны нийлүүлэнийцсэн лт ба баримт бичгийн бүрдүүлэлт** 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. **Оюуны өмчийн эрх** 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. **Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх** 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. **Баталгаат засварын хугацаа** 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа **[моо]** жил байна.
6. **Гэрээнд өөрчлөлт оруулах** 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. **Төлбөр** 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш **[ГТН-д заасан моо]** хоногийн дотор шуурхай хийнэ.
8. **Бараа нийлүүлэх хуваарь** 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. **Алданги оногдуула** 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д



10. Үүргээ биелүүлэх гүй-гээс гэрээг цуцлах 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.

11. Маргааны г шийдвэрлэх 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]

2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:

- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
- 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
- 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
- 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
- 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.

[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]

4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн **[moo]**¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.

5. Алданги оногдуула 9.1. Алданги оногдуулах хувь: **[10%]**

1 Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

х (ГЕН - 9)²

Алдангийн нийт дүн: [10%]

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ³

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

4. Нийлүүлэгч нь _____
нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь; Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

4 Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.